**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР**

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

**Говь-Алтай аймгийн Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

**Аудитын код**: ГАА-2024/170/НА-СТА-ТШЗ

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 **Цахим хаяг**: gunjidmaag@audit.gov.mn

**Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг**

Утас: 99175677 **Цахим хаяг**:erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Э.Сүнжидмаа

Утас: 80048599 **Цахим хаяг**:Sunjidmaae@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2024 он

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт** /Баталгаажсан хувийг оруулах/

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.23 № 67

танай_____________ -ны № _____________ -т

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ш.ЭРДЭНЭБАТ ТАНАА

## Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Засаг даргын тамгын газрын II тайлангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийг эс зөвшөөрвөл аймгийн Засаг даргын тамгын газрын II тайлангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар ажлын хөлснөөс хувь хүний орлогын албан татвар суутгаагүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, худалдан авсан бараа материал хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, төсвийг хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулаагүй, өмнөх оны актын төлбөрийг барагдуулаагүй зэрэг 549,362.7 мянган төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-1-тэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Хантайшир-Уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ой Туульсын хаан жангар арга хэмжээ, Алтайн малчдын түншлэл төсөл арга хэмжээ зохион байгуулагдсан байна.

### Аудитын гол асуудал

Тайланд оны санхүүжилт өмнөх оноос 1,363,903.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь урсгал зардал болон дэмжлэг олгодог 3 байгууллагын цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор өссөн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

0702000287

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.ГҮНЖИДМАА

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл** /мян.төгрөгөөр/

| Үзүүлэлт | 2022.12.31 | 2023.12.31 |
|---|---|---|
| **Санхүүгийн байдлын тайлан** | | |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | | |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | | |
| **Нийт хөрөнгийн дүн** | | |
| Нийт өр төлбөрийн дүн | | |
| Цэвэр хөрөнгө/өмчийн дүн | | |
| **Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | | |
| Үйл ажиллагааны орлогын дүн | 1,342,220.10 | 2,706,123.20 |
| Үйл ажиллагааны зардлын дүн | 1,051,828.10 | 2,706,038.40 |
| **Үйл ажиллагааны үр дүн** | **290,392.00** | **84.80** |
| Үйл ажиллагааны бус үр дүн | | |
| **Үйл ажиллагааны нийт үр дүн** | 290,392.00 | 84.80 |
| **Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** | | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | 28,760.3 |
| Тайлант оны үр дүн | | 28,760.30 |
| **Эцсийн үлдэгдэл** | - | 28,760.30 |
| **Мөнгөн гүйлгээний тайлан** | | |
| Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн | 1,342,220.10 | 2,706,123.20 |
| Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн | | |
| **Үйл ажиллагааны ЦМГ** | 1,342,220.10 | 2,706,123.20 |
| **Хөрөнгө оруулалтын ЦМГ** | 1,342,220.10 | 2,706,035.40 |
| **Санхүүгийн ажиллагааны ЦМГ** | | |
| **Нийт цэвэр мөнгөн гүйлгээ** | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |
| **Төсвийн гүйцэтгэлийн тайлан** | | - |
| **Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн** | - | - |
| Урсгал зардал | | |
| Хөрөнгийн зардал | | |
| **Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр** | **1,342,220.10** | **2,706,038.40** |
| Улсын төсвөөс санхүүжих | | |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | **1,342,220.10** | **2,706,038.40** |

## Гурав:. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 549,362.7 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлж, 800.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 548,652.7 мянган төгрөгийн зөрчил арилгуулах 4 заалт бүхий албан шаардлагыг хүргүүллээ.



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Залруулагдаагүй зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" санал дүгнэлт өгсөн.

**5.2 Албан шаардлага**

1. Галдан бошигт хааны онгоны тахилга зохион байгуулахад 39,958.2 мянган төгрөг, 48 дугаар байрны хажуу талын зураг зуруулахад 16,000.0 мянган төгрөг, 24,500.0 мянган төгрөгөөр ном сум хийлгэж тараасан, бэлэг дурсгал зүйлд 12,991.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан

2. Нээлттэй алтай хөтөлбөрийн хүрээнд малжуулах хөтөлбөрт орсон залуу малчдыг малжуулахад 191,000.0 мянган төгрөг, шинэ сэргэлтийн бодлогын аж үйлдвэрийн сэргэлт малчдыг дэмжих анхдугаар аян алтайн түншлэл малчдын туршлага судлах аялалд 82,000.0 мянган төгрөг,малчдад төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх арга хэмжээний хоолны зардалд 96,880.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.3.үр ашигтай байх"; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

<u>Шийдвэрлэлт:</u> Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж төсвийг үр ашигтай зарцуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

<u>3.</u> Анхан шатны баримтгүй, зориулалт тодорхойгүй бэлнээр 67,563.0 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн, кассын тайлан гаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно". 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/- гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэлт:</u> Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгахгүй байх түүнд хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлсэн

4. Ном 9,600.0 мянган төгрөг, контент 8,875.2 мянган төгрөг, усалгааны систем 4,062.0 мянган төгрөг, алтайн малчдын түншлэл төслийг хэрэгжүүлэх бичиг баримт 6000.0 мянган төгрөг бараа материал хөрөнгийг худалдаж авсан хэдий ч нягтлан бодох бүртгэлд орлого аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.1-т "аж ахуйн бүх ажил, гүйлгээ"; 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага/ гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэлт:</u> Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд орлого авч, бүртгэлжүүлэх албан шаардлага хүргүүлсэн

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 549,362.7 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлж, 800.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 548,652.7 мянган төгрөгийн зөрчил арилгуулах 4 заалт бүхий албан шаардлагыг хүргүүллээ.

Залруулагдаагүй зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн.

**5.2 Албан шаардлага**

1. Галдан бошигт хааны онгоны тахилга зохион байгуулахад 39,958.2 мянган төгрөг, 48 дугаар байрны хажуу талын зураг зуруулахад 16,000.0 мянган төгрөг, 24,500.0 мянган төгрөгөөр нум сум хийлгэж тараасан, бэлэг дурсгал зүйлд 12,991.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан

2. Нээлттэй алтай хөтөлбөрийн хүрээнд малжуулах хөтөлбөрт орсон залуу малчдыг малжуулахад 191,000.0 мянган төгрөг, шинэ сэргэлтийн бодлогын аж үйлдвэрийн сэргэлт малчдыг дэмжих анхдугаар аян алтайн түншлэл малчдын туршлага судлах аялалд 82,000.0 мянган төгрөг,малчдад төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх арга хэмжээний хоолны зардалд 96,880.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.3.үр ашигтай байх”; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.4-т “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”; гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

<u>Шийдвэрлэлт:</u> Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж төсвийг үр ашигтай зарцуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

<u>3.</u> Анхан шатны баримтгүй, зориулалт тодорхойгүй бэлнээр 67,563.0 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн, кассын тайлан гаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно". 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/- гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэлт:</u> Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгахгүй байх түүнд хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлсэн

4. Ном 9,600.0 мянган төгрөг, контент 8,875.2 мянган төгрөг, усалгааны систем 4,062.0 мянган төгрөг, алтайн малчдын түншлэл төслийг хэрэгжүүлэх бичиг баримт 6000.0 мянган төгрөг бараа материал хөрөнгийг худалдаж авсан хэдий ч нягтлан бодох бүртгэлд орлого аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.1-т "аж ахуйн бүх ажил, гүйлгээ"; 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага/ гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэлт:</u> Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд орлого авч, бүргэлжүүлэх албан шаардлага хүргүүлсэн



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

*6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл* /мянган төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4.00 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Аймгийн Засаг даргын тамгын газрын II тайлан | Туулсын хаан жангар арга хэмжээний найруулагч, хөтлөгчийн ажлын хөлснөөс хувь хүний орлогын албан татвар 800.0 мянган төгрөгийг суутган тооцоогүй байна. | 1 | 800.0 | 1 | 800.0 | | | - | - | - | - |
| | Галдан бошигт хааны онгоны тахилга зохион байгуулахад 39,958.2 мянган төгрөг, 48 дугаар байрны хажуу талын зураг зуруулахад 16,000.0 мянган төгрөг, 24,500.0 мянган төгрөгөөр нум сум хийлгэж гаргасан, бэлэг дурсгал зүйлд 12,991.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан | 1 | 93,449.2 | | | 1 | 93,449.2 | - | - | - | - |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Нэлттэй алтай хөтөлбөрийн хүрээнд малжуулах хөтөлбөрт орсон залуу малчдыг малжуулхад 191,000.0 мянган төгрөг, шинэ сэргэлтийн бодлогын аж үйлдвэрийн сэргэлт малчдыг дэмжих анхдугаар аян алтайн түншлэл малчдын туршлага судлах аялалд 82,000.0 мянган төгрөг,малчдад төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх арга хэмжээний хоолны зардалд 96,880.0 мянган төгрөгийг зарцуулсан. | 1 | 365,136.0 | | | 1 | 365,136.0 | - | - | - | - |
| | Анхан шатны баримтгүй, зориулалт тодорхойгүй 67,563.0 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн, кассын тайлан гаргаагүй, | 1 | 67,563.0 | | | 1 | 67,563.0 | | | | |
| | Ном 9,600.0 мянган төгрөг, контент 8,875.2 мянган төгрөг, усалгааны систем 4,062.0 мянган төгрөг, алтайн малчдын түншлэл төслийг хэрэгжүүлэх бичиг баримт 6000.0 мянган төгрөг бараа материал хөрөнгийг худалдаж авсан хэдий ч нягтлан бодох бүртгэлд орлого аваагүй байна. | 1 | 22,414.5 | | | 1.00 | 22,414.5 | - | - | - | - |
| Нийт | | 5 | 549,362.7 | 1 | 800.0 | 4 | 548,562.7 | 0 | - | - | - |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

*6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Аймгийн Засаг даргын тамгын газрын II тайлан | Шилэн дансанд байршуулах 5 саяаас дээш орлогын 2,720,549.2 мянган төгрөгийн 74 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнгийн зарлагын 2,433,640.0 мянган төгрөгийн 58 гүйлгээг хугацаа хоцорч мэдээлсэн байна. | 1 | - | | | 1 | | - | - | - | - |
| Нийт | | 1 | - | 0 | - | 1 | - | - | - | - | - |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР